



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС



Улаанбаатар хот 2021 он

Сонгинохайрхан дүүрэг нь 93521 өрхийн 327580 хүн амтай бөгөөд 2020 онд дүүргийн хэмжээнд 2337 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1133(32.7%) хэргээр буурсан байна.Тайлант хугацаанд гарсан нийт гэмт хэргийн 1787(76.5%) нь хөнгөн, 550(23.5%) нь хүнд гэмт хэрэг байна. Тайлант онд гарсан гэмт хэргийн 321(13.7%) нь согтуугаар үйлдэгдсэн, 110(4.7%) нь хүүхэд оролцсон, 289(12.4%) нь эмэгтэйчүүд оролцсон, 116(4.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Хүснэгт 1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Он	Бүх хэрэг	Гэмт хэргийн ангилал		Согтуугаар үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэйчүүд оролцсон	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас
			хөнгөн	хүнд				
Сонгинохайрхан	2019	3470	2546	924	260	140	288	121
I хэлтэс		1611	1159	452	74	55	102	41
II хэлтэс		831	541	290	82	46	74	25
III хэлтэс		1028	846	182	104	39	112	55
Сонгинохайрхан	2020	2337	1787	550	321	110	289	116
I хэлтэс		1144	841	303	83	48	109	32
II хэлтэс		614	448	166	116	39	94	29
III хэлтэс		579	498	81	122	23	86	55
2020/2019		67.3	70.2	59.5	123.5	78.6	100.3	95.9

2020 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан хэргийн 1144(48.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст,614(23.3%)нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 579(24.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.


Хүснэгт 2.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр

Дүүрэг	Бүх хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2019	2020	өөрчлөлт	2019	2020	өөрчлөлт	2019	2020	өөрчлөлт
Нийслэл	20261	14633	72.2	16347	12572	76.9	3914	2061	52.7
Баянгол	2834	2257	79.6	2569	2123	82.6	265	134	50.6
Баянзүрх	5465	4083	74.7	4307	3540	82.2	1158	543	46.9
Сүхбаатар	3283	2023	61.6	2710	1764	65.1	573	259	45.2
Сонгинохайрхан	3470	2337	67.3	2546	1787	70.2	924	550	59.5
Хан-уул	2055	1650	80.3	1745	1431	82.0	310	219	70.6
Чингэлтэй	2642	1775	67.2	2053	1486	72.4	589	289	49.1
Багануур	167	143	85.6	137	121	88.3	30	22	73.3
Багахангай	14	26	185.7	14	23	164.3	0	3	0.0
Налайх	331	339	102.4	266	297	111.7	65	42	64.6

2020 онд нийслэл хотод 14633 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 5628(27.8%) хэргээр буурсан байна. Нийт гарсан хэргийн 2257(15.4%) нь Баянгол, 4083(27.9%)нь Баянзүрх, 2023(13.8%) нь Сүхбаатар, 2337(16.0%)нь Сонгинохайрхан, 1650(11.3%)нь Хан-уул, 1775(12.1%)

нь Чингэлтэй, 143(1.0%) нь Багануур, 26(0.2%) нь Багахангай, 339(2.3%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна.

Дүрслэл 1. Гэмт хэргийн тоо, дүүргээр



Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Үзүүлэлт	Он	хүний амьд явах эрхийн эсрэг			хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг			хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг		хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	
		Хүнийг алах	хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	хүчиндэх	Заналхийлэх			
Сонгинохайрхан	2019	68	45	1049	981	19	63	58	11	4	
I хэлтэс		26	21	526	502	4	21	19	5	3	
II хэлтэс		20	9	262	244	2	28	27	3	1	
III хэлтэс		22	15	261	235	13	14	12	3	0	
Сонгинохайрхан	2020	47	17	794	711	8	59	53	7	1	
I хэлтэс		24	11	375	342	4	29	26	4	1	
II хэлтэс		14	4	211	175	4	23	22	1	0	
III хэлтэс		9	2	208	194	0	7	5	2	0	
2020/2019		69.1	37.8	75.7	72.5	42.1	93.7	91.4	63.6	25.0	

Тайлант онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 47(2.0%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 794(34.0%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 59 (2.5%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 7(0.3%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн

эсрэг, 6(0.2%) нь эдийн засгийн, 26(1.1%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 52(2.2%) нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг, 7(0.3%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 13(0.6%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 4(0.2%) нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, 2(0.1%) нь хүүхдийн эсрэг, 3(0.1%) нь авлигын эсрэг, 104(4.4%) нь хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэргүүд байна.

Хүснэгт 3- ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Он	Эрүүл мэндийн эсрэг	Эдийн засгийн	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	Хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг	Хүүхдийн эсрэг	Авлигын эсрэг
Сонгинохайрхан	2019	2	9	18	8	15	10	1	145	4	7
I хэлтэс		1	6	13	4	6	8	0	82	3	1
II хэлтэс		0	2	3	3	1	0	0	35	1	4
III хэлтэс		1	1	2	1	8	2	1	28	0	2
Сонгинохайрхан	2020	1	6	26	5	7	13	4	104	2	3
I хэлтэс		1	4	14	2	2	9	2	62	2	2
II хэлтэс		0	1	5	1	2	1	2	30	0	0
III хэлтэс		0	1	7	2	3	3	0	12	0	1
2020/2019		0	66.7	144.4	62.5	46.7	130.0	4 дах	71.7	50.0	42.9


2020 онд Өмчлөх эрхийн эсрэг хэрэг 1257(68.4%) гарсан нь өмнөх оноос 803(2.5%) хэргээр буурсан байна.Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 53.8 хувь нь өмчлөх эрхийн эсрэг хэрэг байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 729(58.8%) нь хулгайлах гэмт хэрэг, 77(6.1%) нь дээрэмдэх, 322(25.6%) нь залилах, 27(2.1%) нь хөрөнгө завших, 23(1.8%) нь эд хөрөнгө устгах гэмтээх, 27(2.1%) нь мал хулгайлах,11(0.9%) нь авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн 689(93.7%) нь хувийн өмч хулгайлах, 3(3.8%) нь автотээврийн хэрэгслэл хулгайлах, 12(2.5%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Хулгайлах гэмт хэрэг өнгөрсөн оноос 527(41.9%) хэргээр буурсан байна. Харин эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг 2(9.5%) хэргээр, авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг 2(22.5%) хэргээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2020/2019
Он	2019				2020				
Өмчлөх эрхийн эсрэг	2060	909	469	682	1257	611	323	323	61.0
Хулгайлах	1256	604	312	340	729	382	186	161	58.0
Хувийн өмч хулгайлах	1181	582	303	296	689	357	181	15	58.3
Автотээврийн хэрэгслэл хулгайлах	31	14	4	13	23	18	2	3	74.2
Халаасны хулгай	38	6	3	29	12	4	3	5	31.6
Дээрэмдэх	131	22	36	73	77	29	16	32	58.8
Залилах	475	156	83	236	322	132	86	104	67.8
Хөрөнгө завших	41	26	8	7	27	11	6	10	65.9
Эд хөрөнгө устгах, гэмтээх	21	11	8	2	23	12	8	3	109.5
Мал хулгайлах	66	66	0	0	27	27	0	0	40.9
Авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах	9	6	2	1	11	7	4	0	122.2

Тайлант хугацаанд гарсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 611(48.6%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 323(25.7%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 323(25.7%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харъяалагдаж байна.

Дүрслэл 2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр



2020 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 362(15.5%) нь даваа гарагт, 344(14.7%) нь мягмар гарагт, 350(14.9%) нь лхагва гарагт, 343(14.7%) нь пүрэв гарагт, 337(14.4%) нь баасан гарагт, 304(13.0%) нь бямба гарагт, 297(12.7%) нь ням гарагт тус тус гарсан байна. Даваа гарагт хамгийн их хэрэг гарсан бөгөөд ням гарагт хамгийн бага хэрэг гарчээ. Тайлант онд өдөрт гардаг хэргийн тоо ойролцоо байсан бөгөөд нэг өдөрт дунджаар 334 хэрэг гарсан байна.

Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн гарагаар

Үзүүлэлт	Он	Гараг						
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2019	525	546	513	520	516	433	417
I хэлтэс		264	261	258	248	214	199	167
II хэлтэс		100	121	132	128	130	112	108
III хэлтэс		161	164	123	144	172	122	142
Сонгинохайрхан	2020	362	344	350	343	337	304	297
I хэлтэс		185	178	174	166	174	125	142
II хэлтэс		96	75	90	105	88	90	70
III хэлтэс		81	91	86	72	75	89	85
2020/2019		69.0	63.0	68.2	66.0	65.3	70.2	71.2

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн 636(27.2%) нь 06-14 цагийн хооронд, 719(30.8%) нь 14-19 цагийн хооронд, 363(15.5%) нь 19-22 цагийн хооронд, 619(26.5%) нь 22-06 цагийн хооронд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэргийн байдлаас харахад 14-19 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан бол 19-22 цагийн хооронд хамгийн бага хэрэг гарсан байна. Цагдаагийн нэгдүгээр хэлтэст 2020 онд гарсан хэргийн хамгийн их буюу 332 нь 06-14 цагийн хооронд гарсан бол өнгөрсөн оны хууд хамгийн их хэрэг 480 бөгөөд 22-06 цагийн хооронд гарч байсан байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар

Үзүүлэлт	Он	Цаг			
		06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2019	926	1028	597	919
I хэлтэс		431	407	293	480
II хэлтэс		223	282	150	176
III хэлтэс		272	339	154	263
Сонгинохайрхан	2020	636	719	363	619
I хэлтэс		332	326	159	327
II хэлтэс		166	211	100	137
III хэлтэс		138	182	104	155
2020/2019		68.7	69.9	60.8	67.4

2020 онд гарсан нийт хэргийн 1012(43.3%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд өнгөрсөн оноос 479(32.1%) хэргээр буурсан байна. Тайлант онд нийт гэр орон сууцанд гарсан хэргийн 455(44.9%) нь гэрт, 160(15.8%) нь орон сууцны байранд, 262(25.9%) нь хувийн байшинд, 32(3.2%) нь зуслангийн байшинд, 37(3.7%) нь нийтийн байранд, 7(0.7%) нь гаражид тус тус гарсан байна.

Тайлант онд нийт гэр, орон сууцанд гарсан хэргийн 466(46.0%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 325(32.1%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 221(21.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Гэр, орон сууц						
			гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангийн байшин	нийтийн байр	гараж
Сонгинохайрхан	2019	1491	665	200	407	62	42	10
I хэлтэс		722	326	75	193	56	10	4
II хэлтэс		455	237	34	151	6	6	3
III хэлтэс		314	102	91	63	0	26	3
Сонгинохайрхан	2020	1012	455	160	262	32	37	7
I хэлтэс		466	210	52	135	22	9	6
II хэлтэс		325	179	31	90	10	8	0
III хэлтэс		221	66	77	37	0	20	1
2020/2019		67.9	68.4	80.0	64.4	51.6	88.1	70.0

Тайлант онд гудамж тайлбайд 421 хэрэг гарсан нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 18.0 хувь болж байна. Тайлант хугацаанд гудамж тайлбайд гарсан нийт хэргийн 153(36.3%) нь гэр хорооллын гудамжинд, 106(25.2%) нь орон сууцны гудамжинд, 45(10.7%) нь ил зогсоол дээр, 48(11.4%) нь автобусын буудал дээр тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 289(40.7%) хэргээр буурсан байна.

Хүснэгт 8. Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай				
			гэр хорооллын гудамж	орон сууцны хорооллын гудамж	ил зогсоол	автобусны буудал
Сонгинохайрхан	2019	710	229	193	60	81
I хэлтэс		222	76	43	14	10
II хэлтэс		177	103	11	6	16
III хэлтэс		311	50	139	40	55
Сонгинохайрхан	2020	421	153	106	45	48
I хэлтэс		116	43	21	13	16
II хэлтэс		145	78	9	10	14
III хэлтэс		160	32	76	22	18
2020/2019		59.3	66.8	54.9	75.0	59.3

Тайлант онд олон нийтийн газарт 160 хэрэг гарсан дүүрэгт гарсан нийт хэргийн 6.8 хувийг эзэлж байгаа бөгөөд олон нийтийн газарт гарсан нийт хэргийн 24(15.0%) нь дэлгүүрт, 17(10.6%) нь зочид буудалд, 27(16.9%) нь бааранд, 11(6.9%) нь ресторан зоогийн газарт, 10(6.2%) нь автовокзал дээр, 7(4.4%) нь цайны газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 195(45.1%) хэргээр буурсан байна.

Хүснэгт 9. Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар						
			дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	авто вокзал	цайны газар
Сонгинохайрхан	2019	355	61	46	67	20	21	20
I хэлтэс		88	15	8	12	3	0	5
II хэлтэс		41	6	3	6	2	1	0
III хэлтэс		226	40	35	49	15	20	15
Сонгинохайрхан	2020	160	24	17	27	11	10	7
I хэлтэс		56	7	6	4	4	1	3
II хэлтэс		26	7	2	2	0	1	0
III хэлтэс		78	10	9	21	7	8	4
2020/2019		45.1	39.3	37.0	40.3	55.0	47.6	35.0


Тайлант онд нийтийн тээвэрт 37 хэрэг гарсан нь өмнөх оноос 1(2.7%) хэргээр өссөн байна.Тайлан хугацаанд нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн 11(29.7%) нь том оврын автобусанд, 2(5.4%) нь дунд оврын автобусанд, 1(2.7%) нь микро автосусанд, 16(43.2%) нь таксинд тус тус гарсан байна.Тайлант онд том болон дунд оврын автобусанд гарсан хэрэг өнгөрсөн оноос буурсан бөгөөд микро автобусанд хэрэг гараагүй байна. 2020 онд таксид гарсан хэрэг өнгөрсөн оноос 2(14.3%) хэргээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр				
			том оврын автобус	дунд оврын автобус	микро	такси
Сонгинохайрхан	2019	36	15	3	0	14
I хэлтэс		14	5	1		7
II хэлтэс		5	1	2		1
III хэлтэс		17	9	0		6
Сонгинохайрхан	2020	37	11	2	1	16
I хэлтэс		5	0	1	1	2
II хэлтэс		1	1	0		0
III хэлтэс		31	10	1		14
2020/2019		102.8	73.3	66.7	0.0	114.3

Тайлант онд нийтийн тээвэрт гарсан хэргийн 5(13.5%) цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 1 (2.7%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 31(83.8%) цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Дүрслэл 3. Хэрэг үйлдэгдсэн газар, дүүргээр



2020 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 174(7.4%) нь аж ахуйн нэгжид, 12(0.5%) нь төрийн байгууллагад, 12(0.5%) нь төрийн бус байгууллагад, 104(4.4%) нь авто зам дээр, 405(17.3%) бусад газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгжид гарсан хэргийн 71(40.8%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 35(20.1%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 68(39.1%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст гарсан байна.


Хүснэгт 11. Хэрэг үйлдэгдсэн газар, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2019	27	16	275	151	409
I хэлтэс		14	10	123	85	333
II хэлтэс		7	2	40	37	67
III хэлтэс		6	4	112	29	9
Сонгинохайрхан	2020	12	12	174	104	405
I хэлтэс		9	8	71	63	350
II хэлтэс		0	4	35	29	49
III хэлтэс		3	0	68	12	6
2020/2019		44.4	75.0	63.3	68.9	99.0

2020 онд хэрэг үйлдсэн хүний тоо 1473 байсан нь өмнөх оноос 332(18.4%) хүнээр цөөрсөн байна. Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн нийт хүний 32(2.2%) нь төрийн албан хаагч, 100(6.8%) нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 18(1.2%) нь төрийн бус байгууллагад ажиллагч, 405

(27.5%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 30(2.0%) нь малчин ,23(1.6%) нь оюутан, 48(3.3%) нь сурагч, 32(2.2%) нь сургууль завсардсан буюу тэнэмэл хүүхэд, 5(0.3%) нь хоригдол, 1(0.1%) нь хугацаат цэргийн албан хаагч, 779(52.9%) нь ажилгүй иргэн байна. Тайлант онд хэрэг үйлдсэн ажилгүй иргэн 779 байсан нь өмнөх оноос 296(27.5%) -оор цөөрсөн байна. Тайлант онд хэрэг үйлдсэн төрийн албан хаагч 68.4 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгч 2.0 хувиар, сургууль завсардсан, тэнэмэл иргэд 2.5 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 4. Гэмт хэрэг үйлдэгдсэн байршил, дүүргээр



Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн хүний 706(47.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 377(25.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 390(26.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст бүртгэлтэй байна.

Хүснэгт 12. Хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Үзүүлэлт	Сонгинохайрхан	Сонгинохайрхан			Сонгинохайрхан	Сонгинохайрхан			2020/2019
		I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс		I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	
Он	2019				2020				
Төрийн албан хаагч	19	7	5	7	32	21	4	7	168.4
Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	121	37	8	76	100	28	13	59	82.6
Төрийн бус байгууллагын ажилтан	25	14	3	8	18	7	4	7	0.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	397	210	85	102	405	250	78	77	102.0
Малчин	28	20	1	7	30	27	0	3	0.0
Оюутан	42	13	5	24	23	7	5	11	54.8
Сурагч	76	29	25	22	48	29	10	9	63.2
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	13	2	1	10	32	15	7	10	2.5 дах
Хоригдол	8	4	3	1	5	0	5	0	62.5
Хугацаат цэргийн алба хаагч	1	1			1			1	100.0
Ажилгүй	1075	503	287	285	779	322	251	206	72.5
Нийт	1805	840	423	542	1473	706	377	390	81.6

Тайлант онд хэрэг үйлдсэн нийт хүний 249(16.9%) нь эмэгтэй, 64(4.3%) нь 15 хүртэлх насны, 69(4.7%) нь 16-17 настай, 317(21.5%) нь 18-24 настай, 298(20.2%) нь 25-29 настай, 229(15.4%) нь 30-34 настай, 171(15.5%) нь 35-39 настай, 129(8.8%) нь 40-44 настай, 91(6.2%) нь 45-49 настай, 58(3.9%) 50-54 настай, 30(2.0%) нь 55-59 настай, 17(1.1%) нь 60 аас дээш настай байна. Тайлант онд хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 9(3.8%) хүнээр, 15 хүртэлх насны хүүхдийн тоо 1(1.6%) ээр нэмэгдсэн бол 60 болон түүнээс дээш насны хүн 4(19.0%) ээр буурсан байна.

Хүснэгт 13. Хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2020/2019	
Он	2019				2020					
Бүх хүн	1805	840	423	542	1473	706	377	390	81.6	
Эмэгтэй	240	96	62	82	249	99	76	74	103.8	
насны бүлэг	15 хүртэлх	63	26	24	13	64	32	18	14	101.6
	16-17	102	47	22	33	69	33	22	14	67.6
	18-24	383	174	99	110	317	139	93	85	82.8
	25-29	377	184	76	117	298	138	68	92	79.0
	30-34	301	155	62	84	229	109	61	59	76.1
	35-39	239	87	57	95	171	79	40	52	71.5
	40-44	133	66	36	31	129	70	29	30	97.0
	45-49	89	47	19	23	91	47	23	21	102.2
	50-54	60	30	14	16	58	34	12	12	96.7
	55-59	37	15	8	14	30	16	7	7	81.1
60+	21	9	6	6	17	9	4	4	81.0	

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн хүний 28(1.9%) нь боловсролгүй, 136(9.2%) нь бага боловсролтой, 358(24.3%) нь суурь боловсролтой, 739(49.9%) нь бүрэн дунд боловсролтой, 43(2.9%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 169(11.5%) нь дээд боловсролтой байна.

Хүснэгт 14. Хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2019	40	141	455	928	69	172
I хэлтэс		16	61	217	430	28	88
II хэлтэс		3	32	106	251	8	23
III хэлтэс		21	48	132	247	33	61
Сонгинохайрхан	2020	28	136	358	739	43	169
I хэлтэс		7	70	201	351	18	59
II хэлтэс		11	27	91	206	5	37
III хэлтэс		10	39	66	182	20	73
2020/2019		70.0	96.5	78.7	79.6	62.3	98.3

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн улмаас 11707.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оноос 2673.5(29.6%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 8974.8 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оноос 2255.9(33.6%) сая төгрөгөөр, хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 417.1(53.0%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд гарсан хэргийн байдлыг харахад гэмт хэргийн гаралтын тоо өмнөх оноос буурсан боловч учирсан хохирлын хэмжээ нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	Ангилал		Өмчийн хэлбэр		
			хөнгөн	хүнд	төрийн	орон нутгийн	хувийн
Сонгинохайрхан	2019	9033.5	6718.9	2314.6	6.9	17.6	9009
I хэлтэс		5706.5	4088.6	1618	5.6	9.1	5691.9
II хэлтэс		2002.2	1617.7	384.4	1	8	1993.2
III хэлтэс		1324.7	1012.6	312.1	0.3	0.5	1323.9
Сонгинохайрхан	2020	11707	8974.8	2731.7	628.2	4.5	11074
I хэлтэс		6646.7	5072.5	1574.2	603	4.5	6039.3
II хэлтэс		2886.8	2541.1	345.6	1	0	2885.8
III хэлтэс		2173	1361.2	811.9	24.2	0	2148.8
2020/2019		129.6	133.6	118.0	91 дах	25.6	122.9

Тайлант онд гарсан гэмт хэргийн улмаас 941 хүн гэмтсэн бөгөөд 676(71.8%) хүн хөнгөн , 109(11.6%) хүн хүндэвтэр, 56(5.9%) хүн хүнд гэмтэл авсан байна. Гэмтсэн хүний тоо өмнөх оноос 148 (13.6%) хүнээр цөөрсөн байна.

Хүснэгт 16. Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн

Үзүүлэлт	Он	Гэмтсэн хүн	Гэмтлийн зэрэг			Нийт гэмтсэн хүнээс			
			хөнгөн	хүндэвтэр	хүнд	эмэгтэй	7 хүртэлх	8--13	14-17
Сонгинохайрхан	2019	1089	899	131	59	518	6	41	52
I хэлтэс		639	530	76	33	293	4	21	30
II хэлтэс		180	140	21	19	100	2	10	12
III хэлтэс		270	229	34	7	125	0	10	10
Сонгинохайрхан	2020	941	676	109	56	355	5	21	41
I хэлтэс		460	365	64	31	186	4	12	26
II хэлтэс		160	113	29	18	73	1	5	5
III хэлтэс		221	198	16	7	96	0	4	10
2020/2019		86.4	75.2	83.2	94.9	68.5	83.3	51.2	78.8

Тайлант онд 19818 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 3450(21.1%) зөрчлөөр нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 12075(60.9%) нь ердийн журмаар шийдвэрлэсэн, 7743(39.1%) нь хялбаршуулсан журмаар шалгасан зөрчил байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн зөрчлийн тоо

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2020/2019
Он	2019				2020				
Нийт зөрчил	16368	6618	3627	6123	19818	8313	5236	6269	121.1
ердийн журмаар шийдвэрлэсэн	x	x	x	x	12075	5277	2671	4127	x
хялбаршуулсан журмаар шалгасан	x	x	x	x	7743	3036	2565	2142	x

2020 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт зөрчлийн 6618(40.4%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 3627(22.2%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 6123(37.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

*Сонгинохайрхан дүүргийн
Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэст эмхэтгэв.*